



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цагаанчулуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2025/140/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улиастай сум
2025 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Болдбаатар
Утас: 99105506
Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn
Хаан соёмбо аудит ХХК -гэрээт аудитор:
Б.Цэрэндэжид
Утас: 99812811
Цахим хаяг: tserendejid1109@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРНИЙ АУДИТЫН ГАЗАР

Сүхбаатар дүүрэг, Завхан аймаг
3 тас Фаяг 2046-36-12
Нийслэл: завхан.аимаг.гов.орг

2024.02.11 № 43

танил

төг

ЦАГААНЧУЛУУТ СУМЫН
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧИЙН ҮҮРГИЙГ ХАВСРАН
ГҮЙЦЭТГЭГЧ Л ЧУЛУУНЦЭЦЭГ-Т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагаанчулуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагаанчулуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан, Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Цагаанчулуут сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2024 онд 558,285.9 мянган төгрөгийн санхүүжилттэй, 41,077.8 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй, 3,641.4 мянган төгрөгийн авлагатай ажилласан байна.

Аудитын гол асуудал

Цагаанчулуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн 32 нэр төрлийн 16,523.0 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгөтэй, цэцэрлэгийн хүүхдийн хоолыг нормативт зардлаас 952.2 мянган төгрөгөөр дутуу олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Тус цэцэрлэг нь 2024 онд нөхөн хангалтын зардлаас 1,500.0 мянган төгрөгийн 13 ширхэг багц сургалтын хэрэглэгдэхүүн, хүүхэд хамгааллын зардлаар 660.0 мянган төгрөгийн буйдан, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 14,185.6 мянган төгрөгийн 5 ширхэг зөөврийн компьютер нийлүүлэгдсэнийг данс бүртгэлд тусгажээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

8175 2056

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг

ДАРГА, ТЭРГҮҮЛЭГ
АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Байгууллагын нэр: Цагаанчулуут ЕБС

Тайлант хугацаа: 2024.12.31

/ төгрөгөөр /

Данс	Балансын зүйл	Эжний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	173,195,286.78	246,997,765.90
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	41,733,433.33	119,452,730.05
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	41,733,433.33	119,452,730.05
3121	Төгрөг	41,733,433.33	119,452,730.05
31211	Төрийн сангийн харилцах	41,733,433.33	119,452,730.05
314	Замд яваа мөнгөн хөрөнгө		
33	АВЛАГА		
34	УРЬДЧИЛГАА		
35	БАРАА МАТЕРИАЛ	131,461,853.45	127,545,035.85
351	Түүхий эд материал	35,850,577.45	33,167,039.85
3511	Тусгай зориулалттай материал	35,827,777.45	33,144,239.85
3513	Эм боох материал	22,800.00	22,800.00
353	Бэлэн бүтээгдэхүүн	10,071,810.00	8,387,800.00
354	Хангамжийн материал	81,219,466.00	82,450,196.00
3541	Бичиг хэргийн материал	970,800.00	675,600.00
3542	Аж ахуйн материал	958,400.00	380,800.00
3543	Сэлбэг хэрэгсэл	1,264,000.00	1,384,000.00
3545	Барилгын засварын материал	5,812,700.00	5,149,100.00
3546	Хүнсний материал	10,595,740.00	17,967,630.00
3547	Бусад хангамжийн материал	61,617,826.00	56,893,066.00
356	Мал амьтад	4,320,000.00	3,540,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА		
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,502,076,576.18	3,501,762,399.14
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,502,076,576.18	3,501,762,399.14
392	Биет хөрөнгө	3,456,993,076.18	3,457,008,899.14
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,560,890,483.70	3,560,890,483.70
39202	Хуримтлагдсан элэгдэл	-459,547,103.60	-555,232,589.24

39203	Авто-тээврийн хэрэгсэл	7,000,000.00	7,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		-3,500,000.04
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	213,842,520.86	398,340,580.86
39206	Хуримтлагдсан элэгдэл	-34,358,996.54	-96,064,947.42
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	162,891,232.13	160,661,272.13
39208	Хуримтлагдсан элэгдэл	-56,540,714.56	-75,319,165.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	41,670,000.00	41,670,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,257,732.04	-10,422,232.08
39217	Ном	24,403,386.23	28,985,496.23
393	Биет бус хөрөнгө	45,083,500.00	44,753,500.00
39301	Програм хангамж	2,481,770.00	1,650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,014,270.00	-1,512,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	44,616,000.00	44,616,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,675,271,862.96	3,748,760,165.04
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		88,747,448.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		88,747,448.00
413	Өглөг		88,747,448.00
4136	Бусад өглөг		88,747,448.00
41361	Байгууллагад төлөх өглөг		88,747,448.00
414	Урьдчилж орсон орлого		
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
422	Урт хугацаат зээл		
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,675,271,862.96	3,660,012,717.04
51	Засгийн газрын хувь оролцоо	3,675,271,862.96	3,660,012,717.04
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	290,690,978.95	290,690,978.95
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө		
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	290,690,978.95	290,690,978.95
51101	Өмч: - төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн	2,693,467,250.73	2,678,354,307.31
5121	Өмнөх үеийн үр дүн	2,693,467,250.73	2,693,613,453.23
5122	Тайланг үеийн үр дүн		-15,259,145.92
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	691,113,633.28	690,967,430.78
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,675,271,862.96	3,748,760,165.04

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Байгууллагын нэр: Цагаанчулуут ЕБС

Тайлант хугацаа: 2024.12.31

/ төгрөгөөр /

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,572,439,240.79	1,682,557,590.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,432,076,740.79	35,564,490.40
120	Нийтлэг татварын бус орлого	1,432,076,740.79	35,564,490.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,020,100.00	2,897,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,020,100.00	2,757,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		140,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,404,753,170.79	31,850,580.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	24,303,470.00	816,610.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,140,362,500.00	1,646,993,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	939,534,100.00	1,412,992,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	939,534,100.00	1,412,992,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	200,828,400.00	234,000,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	200,828,400.00	234,000,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,188,856,825.94	1,697,816,736.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,188,856,825.94	1,697,816,736.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,106,463,133.63	1,623,277,387.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	684,580,077.57	1,019,132,003.72
210101	Үндсэн цалин	472,854,479.57	633,745,172.91
210102	Нэмэгдэл	179,630,082.00	332,374,380.81
210104	Урамшуулал	32,095,516.00	53,012,450.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,156,160.54	128,215,919.62
210201	Тэтгэврийн даатгал	60,654,793.66	87,643,283.17
210202	Тэтгэмжийн даатгал	7,135,857.89	10,412,479.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,581,086.39	5,309,897.64
210204	Ажилгүйдлийн даатгал	1,341,602.60	4,970,050.36
210205	Эрүүл мэндийн даатгал	13,442,840.00	19,880,208.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	146,994,047.69	166,972,190.73
210301	Гэрэл, цахилгаан	11,119,288.69	29,947,022.73
210302	Түлш, халаалт	134,574,759.00	135,345,168.00

210303	Цэвэр, бохир ус	1,300,000.00	1,680,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,104,755.00	27,762,058.00
210401	Бичиг хэрэг	1,450,400.00	6,052,200.00
210402	Тээвэр, шатахуун	2,105,850.00	3,709,850.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,261,000.00	3,629,400.00
210408	Бараа материал акталсны зардал	4,287,505.00	14,370,608.00
2105	Нормативт зардал	40,039,135.00	38,305,180.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	410,385.00	
210502	Хоол, хүнс	39,628,750.00	38,305,180.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,074,400.00	6,832,200.00
210604	Урсгал засвар	6,074,400.00	6,832,200.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,738,800.00	6,925,257.94
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	979,100.00	2,757,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,759,700.00	4,167,957.94
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	127,775,737.83	229,132,577.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,121,880.00	35,270,820.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,705,000.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	106,948,857.83	193,861,757.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	82,393,692.31	74,539,348.87
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,462,840.00	33,322,660.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,994,520.00	19,701,460.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,468,320.00	13,621,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	49,930,852.31	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	49,930,852.31	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		41,216,688.87
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		41,216,688.87
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
	Дотоод эх үүсвэрээр		
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,383,582,414.85	-15,259,145.92
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,790,000.00	
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	110,000.00	
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	1,680,000.00	
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-1,790,000.00	
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,381,792,414.85	-15,259,145.92

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Байгууллагын нэр: Цагаанчулуут ЕБС

Тайлант хугацаа: 2024.12.31

/ төгрөгөөр /

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,143,382,600.00	1,649,890,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,020,100.00	2,897,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,020,100.00	2,897,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,020,100.00	2,897,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,020,100.00	2,757,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		140,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,140,362,500.00	1,646,993,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	939,534,100.00	1,412,992,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	939,534,100.00	1,412,992,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	200,828,400.00	234,000,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	200,828,400.00	234,000,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,083,393,968.11	1,499,221,551.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,083,393,968.11	1,499,221,551.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	997,636,985.80	1,426,444,212.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	684,932,077.57	1,019,132,003.75
210101	Үндсэн цалин	461,716,321.42	655,237,401.86
210102	Нэмэгдэл	190,389,487.15	301,500,381.28
210104	Урамшуулал	32,826,269.00	62,394,220.61
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,777,380.54	128,215,919.59
210201	Тэтгэврийн даатгал	60,302,793.66	87,643,283.14
210202	Тэтгэмжийн даатгал	7,135,857.89	10,412,479.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,581,086.39	5,309,897.64
210204	Ажилгүйдлийн даатгал	1,341,602.60	4,970,050.36
210205	Эрүүл мэндийн даатгал	13,416,040.00	19,880,208.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	146,994,047.69	187,195,211.13
210301	Гэрэл, цахилгаан	11,119,288.69	29,947,022.73
210302	Түлш, халаалт	134,574,759.00	155,568,188.40
210303	Цэвэр, бохир ус	1,300,000.00	1,680,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		
2105	Нормативт зардал	44,142,750.00	45,652,670.00
210502	Хоол, хүнс	44,142,750.00	45,652,670.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,217,500.00	5,588,600.00
210604	Урсгал засвар	1,217,500.00	5,588,600.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,738,800.00	7,000,257.94
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	979,100.00	2,757,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,759,700.00	4,242,957.94
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,834,430.00	33,659,550.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,078,730.00	26,741,250.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,755,700.00	6,918,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	85,756,982.31	72,777,338.87
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,826,130.00	31,560,650.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,357,810.00	17,939,450.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,468,320.00	13,621,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	49,930,852.31	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	49,930,852.31	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		41,216,688.87
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		41,216,688.87
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	59,988,631.89	150,668,848.72
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	18,492,000.00	72,949,552.00
	Дотоод эх үүсвэрээр	18,492,000.00	72,949,552.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	18,492,000.00	72,949,552.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-18,492,000.00	-72,949,552.00
145	Бусад эх үүсвэр		
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	41,496,631.89	77,719,296.72
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		41,733,433.33
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		119,452,730.05

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: Цагаанчулуут ЕБС

Тайлант хугацаа: 2024.12.31

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	290,690,978.95	691,113,633.28	2,693,467,250.73	3,675,271,862.96
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			146,202.50	146,202.50
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-146,202.50		-146,202.50
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Тайлант үеийн үр дүн			22,634,661.95	22,634,661.95
8				
9				
10	20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	290,690,978.95	691,113,633.28	2,693,467,250.73	3,675,271,862.96
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			146,202.50	146,202.50
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-146,202.50		-146,202.50
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн			-15,259,145.92	-15,259,145.92
18				
19	20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	290,690,978.95	690,967,430.78	2,678,354,307.31	3,660,012,717.04

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Байгууллагын нэр: Цагаанчулуут ЕБС

Тайлант хугацаа: 2024.12.31

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,691,428,500.00	1,572,171,103.28	119,257,396.72	92.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,691,428,500.00	1,572,171,103.28	119,257,396.72	92.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,654,905,800.00	1,499,393,764.41	155,512,035.59	90.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,106,199,600.00	1,019,132,003.75	87,067,596.25	92.13
210101	Үндсэн цалин	763,739,500.00	655,237,401.86	108,502,098.14	85.79
210102	Нэмэгдэл	291,586,700.00	301,500,381.28	-9,913,681.28	103.4
210104	Урамшуулал	50,873,400.00	62,394,220.61	-11,520,820.61	122.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	138,275,400.00	128,215,919.59	10,059,480.41	92.73
210201	Тэтгэврийн даатгал	94,027,100.00	87,643,283.14	6,383,816.86	93.21
210202	Тэтгэмжийн даатгал	11,062,000.00	10,412,479.85	649,520.15	94.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,531,000.00	5,309,897.64	221,102.36	96
210204	Ажилгүйдлийн даатгал	5,531,000.00	4,970,050.36	560,949.64	89.86
210205	Эрүүл мэндийн даатгал	22,124,300.00	19,880,208.60	2,244,091.40	89.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	227,500,500.00	187,195,211.13	40,305,288.87	82.28
210301	Гэрэл, цахилгаан	10,432,100.00	29,947,022.73	-19,514,922.73	287.07
210302	Түлш, халаалт	216,106,200.00	155,568,188.40	60,538,011.60	71.99
210303	Цэвэр, бохир ус	962,200.00	1,680,000.00	-717,800.00	174.6
2104	Хангамж, бараа материалын зардал				
2105	Нормативт зардал	59,114,400.00	45,652,670.00	13,461,730.00	77.23
210502	Хоол, хүнс	59,114,400.00	45,652,670.00	13,461,730.00	77.23
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,500,000.00	5,588,600.00	911,400.00	85.98
210604	Урсгал засвар	6,500,000.00	5,588,600.00	911,400.00	85.98
2107	Томилолт, зочны зардал				
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,595,000.00	18,507,907.94	1,087,092.06	94.45
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,640,800.00	2,757,300.00	883,500.00	75.73
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15,954,200.00	15,750,607.94	203,592.06	98.72
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	97,720,900.00	95,101,452.00	2,619,448.00	97.32
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	90,802,600.00	88,183,152.00	2,619,448.00	97.12
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,918,300.00	6,918,300.00		100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,522,700.00	72,777,338.87	-36,254,638.87	199.27
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,522,700.00	31,560,650.00	4,962,050.00	86.41
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,901,500.00	17,939,450.00	4,962,050.00	78.33
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,621,200.00	13,621,200.00		100
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		41,216,688.87	-41,216,688.87	

213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		41,216,688.87	-41,216,688.87	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ				
	Дотоод эх үүсвэрээр				
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,240,313,500.00	1,649,890,400.00	-	133.02
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,006,313,000.00	1,412,992,600.00	-	140.41
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,006,313,000.00	1,412,992,600.00	-	140.41
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого				
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	234,000,500.00	234,000,500.00		100
132001	Орон нутгийн төсвөөс	234,000,500.00	234,000,500.00		100
133	ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС				
134	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		2,897,300.00	-2,897,300.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		2,757,300.00	-2,757,300.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		140,000.00	-140,000.00	
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР				
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		41,733,433.33	-41,733,433.33	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		119,452,730.05	-	119,452,730.05
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО				
3	Төсвийн байгууллага	1	1		100
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	41	41		100
6	Удирдах ажилтан	1	1		100
7	Гүйцэтгэх ажилтан	28	27	1	96.43
8	Үйлчлэх ажилтан	12	12		100
10	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	200	200		100
12	Төрийн өмчит ЕБС	200	200		100

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Нэмэлт санхүүжилт байхгүй

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Цагаанчулуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэл:

- Бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх

Цагаанчулуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн зорилго: Суралцагчийн эзэмших чадамжийг хөгжүүлэхэд бүх талын оролцоо, хамтын ажиллагааг хангаж ээлжит хичээлийн чанарыг сайжруулах зорилго зорилт чиг үүргийн хүрээнд ажиллаж байна.

Цагаанчулуут сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 онд Багш нарын гүйцэтгэлийн үнэлгээгээр 10 багш 1 дүгээр индексээр, 5 багш 2 дугаар индексээр, 1 багш 3 дугаар индексээр, 1 багш 4 дүгээр индексээр үнэлэгдсэн байна. Элсэлтийн ерөнхий шалгалтын дунджаар аймагт 4 дүгээр байр эзэлжээ. Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр 1 дүгээр индексээр үнэлэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Цагаанчулуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Боловсролын ерөнхий хууль
2. Төрийн албаны тухай хууль
3. Төрийн хэмнэлтийн тухай хууль
4. Төсвийн тухай хууль
5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
6. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
7. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
8. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
9. Хөдөлмөрийн тухай хууль
10. Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд орсон өөрчлөлт:

2024 оны 03 сарын 27-ны 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосон, Боловсролын ерөнхий хууль 2024 оны 07-р сарын 07-нд батлагдсан. Засгийн газрын 2024 оны 08 сарын 28-ны 53 дугаар тогтоолоор "Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр" шинэчлэгдэн батлагдсан, Сангийн Сайдын 2024 оны 04 сарын 01-ний А/52 тушаалаар дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн баталсан.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын багийг байгуулж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Мөн Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд Сургуулийн захирал, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагаанчулуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цагаанчулуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 748.3 мянган төгрөгөөр буюу 1.99 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

<i>/мянган төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага			
Бараа материал	131,461.9	127,545.0	3,916.8
Үндсэн хөрөнгө	3,502,076.6	3,501,762.4	445.2
Нийт хөрөнгө	3,633,538.5	3,629,307.4	4,231.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,675,271.9	3,660,012.7	15,259.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,675,271.9	3,660,012.7	15,259.2

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайланд онд:

Бараа материалын эхний үлдэгдэл 131,461.9 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 87867,5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар 816.6 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 78,230.3 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 14,370.6 мянган төгрөгийн хөрөнгийг акталж эцсийн үлдэгдэл 127,545.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,916.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 161,697.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хандиваар 18,251.8 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 1,335.0 төгрөгийн хөрөнгийг данс хооронд шилжүүлэн авч, хөрөнгө оруулалтаар 13,598.8 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 7,529,1 мянган төгрөгийн хөрөнгийг шийдвэрийн дагуу акталж, 1,335.0 төгрөгийн хөрөнгийг шилжүүлж жилийн эцэст 4,243,813.8 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 193,861.8 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 15,259.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,094,430.1 мянган төгрөг, нийт зарлагыг 1,094,430.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,094,430.1 мянган төгрөгийг улсын төсөвт суллуулахаар төсөвлөсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,572,171.1 мянган төгрөг буюу 92.95 хувьтай байна. Энэ нь цалингийн зардал 87,067.6 НДШ-ийн зардал 10,059.5 байр ашиглалтай холбоотой зардал 43,305.3, хоол 13,461.7 Урсгал засвар 911.4 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 1,087.1 Бараа үйлчилгээний бусад зардал 2,619.4 Төрөөс иргэдэд олгох урамшуулал 496.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
Орон нутгийн төсвөөс санхүүжих					
71802	Ерөнхий боловсрол				
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	1,638.0	1,638.0	0	100%
80233	Хүүхэд хамгаалал	1,738.8	1,729.6	9.2	99.47%
80312	Сургалт семинар	1,203.5	1,203.5		100%
81605	Эрүүл мэндийг дэмжих	1,571.7	1,571.7	-	100%
81801	Үдийн цай хөтөлбөр	22,901.5	17,939.5	4,962.0	78.33%
81806	Дотуур байрын хүүхдийн хоол	224,021.7	210,560.0	13,461.7	75.8%
81816	Зөв монгол хүүхэд	57,757.0	57,757.0		100%
81823	Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	4,715.1	2,569.5	2,145.6	54.5%
81827	Бичиг үсгийн боловсрол	15,570.2	15,569.9	0.3	99.89%
81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжүүлэх	1,042,673.8	953,870.7	88,803.1	95.17%
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	77,605.8		8,994.9	65.25%
81844	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орчинг сайжруулах	340.0	340.0		100%
81848	Сурах бичгийн түрээс	3,640.8	2,757.3	883.5	75.73%
81875	Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	2,050.4	2,050.4		100%
НИЙТ		1,733,161.9	1,613,709.2	119,452.7	93.1%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Байхгүй

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

/мянган төгрөг/

№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Харьцуулалтын аргаар тендер шалгаруулалт	Дотуур байрын хүүхдийн хоол	59114.4	45652.7
2	Харьцуулалтын аргаар тендер шалгаруулалт	Үдийн хоол хөтөлбөр	22901.5	17939.4
ДҮН			82015.9	63592.1

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цагаанчулуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Хаан соёмбо аудит” ХХК-ийн гэрээт аудитор Б.Цэрэндэжид гүйцэтгэж Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд анхан шатны хяналт хийж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Цагаанчулуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг 1,967,816.7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 39,353.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 31,485.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 6 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Цагаанчулуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно..

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 379.9 мянган төгрөгийн актын төлбөрын 100% төлж барагдуулсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	379.9	1	379.9	100%
Нийт дүн	1	379.9	1	379.9	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал тодорхойлогдоогүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,044.3 мянган төгрөгийн алдаа илэрч зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

Байхгүй

Шийдвэрлэсэн байдал: Байхгүй

5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй

5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй

5.3 Зөвлөмж

- **Илэрсэн алдаа:** Хүүхдийн үдийн хоолыг нормативт зардлаас 1,445.5 мянган төгрөгөөр дутуу, дотуур байрын хүүхдийн хоолны зардлыг нормативаас 598.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан.
- **Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх" заалт, Засгийн газрын 2019 оны 450, 2024 оны 237 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлэн ажиллах

Илэрсэн алдаа: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 23 төрлийн 20,791.4 мянган төгрөгийн хөрөнгө элэгдээрээ анхны өртгөө нөхсөн үлдэгдэл өртөггүй хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дахин үнэлгээ хийх шалгуур хангасан хөрөнгөнд үнэлгээ хийж бүртгэлд тусгах, цаашид ашиглах боломжгүй хөрөнгүүдийг холбогдох газрын зөвшөөрлийн дагуу данснаас хасах арга хэмжээ авч, үндсэн хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх;

Энэхүү зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингөөс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БҮРҮҮ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаврдлага		Зөвлөмж		Хариудлага тооцуулах албан шаврдлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дотуур байрны хуудсийн хоолыг нормативт зардлаас дутуу олгосон	1	598.8					1	598.8				
Хуудсийн үдийн хоолыг нормативт зардлаас дутуу олгосон	1	1,445.5					1	1,445.5				
Анхны ертөө элгдлээрээ нөхсөн 0 үлдэгдэлтэй байгаа 23 нэр төрлийн 20,791,496.16 төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж ашиглалтын хугацааг сунгах дүн												
		2044.3						2044.3				

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:


АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

БОЛОВСРУУЛСАН:

Огноо: 2025-01-18



Ц.ОЮУНСУВД

Х.БОЛДБААТАР

Д.БАТ-УНДРАА

"УААН СОЁМО АУДИТ" ХХК ТЭРЭЭТ АУДИТОР

Огноо: 2025-01-18

Б.ЦЭРЭНДЭЖИД